

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сантмаргаз сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/173/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: [zayag@audit.gov.mn](mailto:zayag@audit.gov.mn)

Интер аудит ХХК

Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг

Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: [altan\\_fin@yahoo.com](mailto:altan_fin@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.6.3 Нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	14
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит .....	14
4.2.1 Залруулсан алдаа.....	14
4.2.2 Төлбөрийн акт.....	14
4.2.3 Албан шаардлага .....	14
4.2.4 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## 1. Аудитын санал дүгнэлт

  
**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81000 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

№ 1302/22

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

САНТМАРГАЦ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН  
ЭРХЛЭГЧ С.БЯМБАДОРЖ ТАНАА

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сантмаргац сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сантмаргац сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013021893

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,120.00</u></b>	<b><u>5,245.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	5,120.00	5,245.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,120.00	5,245.00
35410	Бичиг хэргийн материал	1,470.50	1,470.50
35420	Аж ахуйн материал	269.50	394.50
35430	Сэлбэг хэрэгсэл	230.00	230.00
35450	Барилгын засварын материал	150.00	150.00
35470	Бусад хангамжийн материал	3,000.00	3,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>644,790.05</u></b>	<b><u>632,625.53</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	644,790.05	632,625.53
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	642,536.05	630,371.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	625,178.66	625,178.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,839.29)	(31,258.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,227.35	32,664.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,399.84)	(22,759.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,817.61	13,817.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,562.96)	(8,490.24)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,239.88	1,239.88
39217	Ном	19,874.63	19,979.03
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,254.00	2,254.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,254.00	2,254.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>649,910.05</u></b>	<b><u>637,870.53</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>649,910.05</u></b>	<b><u>637,870.53</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	649,910.05	637,870.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	79,988.92	79,988.92
51101	Өмч: - төрийн	79,988.92	79,988.92
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(48,043.83)	(60,083.34)
51210	Өмнөх үеийн үр дүн	(48,043.83)	(48,043.83)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(12,039.52)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	617,964.95	617,964.95
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>649,910.05</u></b>	<b><u>637,870.53</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>160,810.80</b>	<b>137,638.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,461.30</b>	<b>44.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,461.30	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,461.30	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,070.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	391.30	-
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	44.40
122001	Хандив тусламж /дотоод/	-	44.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>159,349.50</b>	<b>137,594.20</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	159,349.50	137,594.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	159,349.50	137,594.20
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>172,121.22</b>	<b>149,678.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>172,121.22</b>	<b>149,678.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	147,375.95	148,988.59
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	57,900.08	58,125.95
210101	Үндсэн цалин	57,900.08	58,125.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,126.60	7,558.70
210201	Тэтгэврийн даатгал	4,843.78	5,141.96
210202	Тэтгэмжийн даатгал	570.71	559.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	456.57	625.04
210204	Ажилгүйдлийн даатгал	114.14	112.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,141.41	1,119.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,476.06	67,713.73
210301	Гэрэл, цахилгаан	183.36	538.03
210302	Түлш, халаалт	67,178.30	67,175.70
210303	Цэвэр, бохир ус	114.40	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,275.40	667.90
210401	Бичиг хэрэг	174.92	63.00
210402	Тээвэр, шатахуун	589.28	205.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235.40	235.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	275.80	60.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	104.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	95.60	95.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95.60	95.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	150.00
210604	Урсгал засвар	-	150.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	70.50	252.00
210702	Дотоод албан томилолт	70.50	252.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,691.80	2,035.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,570.30	1,914.30

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	121.50	121.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,739.91	12,388.92
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,739.91	12,388.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,745.27	689.52
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	2,697.97	689.52
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,697.97	689.52
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	22,047.30	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,047.30	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(11,310.42)</u></b>	<b><u>(12,039.52)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(11,310.42)</u></b>	<b><u>(12,039.52)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,988.92	617,964.95	(48,043.83)	649,910.05
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	79,988.92	617,964.95	(48,043.83)	649,910.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,988.92	617,964.95	(48,043.83)	649,910.05
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,039.52)	(12,039.52)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,988.92	617,964.95	(60,083.34)	637,870.53

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>160,419.50</u></b>	<b><u>137,594.20</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,070.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,070.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,070.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,070.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>159,349.50</b>	<b>137,594.20</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	159,349.50	137,594.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	159,349.50	137,594.20
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>160,359.50</u></b>	<b><u>137,414.20</u></b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>160,359.50</b>	<b>137,414.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>135,614.23</b>	<b>136,724.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	57,446.17	58,125.95
210101	Үндсэн цалин	53,619.02	50,184.17
210102	Нэмэгдэл	3,827.15	7,941.78
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,558.70	7,558.70
210201	Тэтгэврийн даатгал	5,319.10	5,319.10
210202	Тэтгэмжийн даатгал	559.90	559.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	447.90	447.90
210204	Ажилгүйдлийн даатгал	112.00	112.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,119.80	1,119.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,476.06	68,063.73
210301	Гэрэл, цахилгаан	183.36	888.03
210302	Түлш, халаалт	67,178.30	67,175.70
210303	Цэвэр, бохир ус	114.40	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,059.60	563.90
210401	Бичиг хэрэг	174.92	63.00
210402	Тээвэр, шатахуун	589.28	205.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235.40	235.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60.00	60.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	95.60	95.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95.60	95.60
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	150.00
210604	Урсгал засвар	-	150.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	70.50	252.00
210702	Дотоод албан томилолт	70.50	252.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,907.60	1,914.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,786.10	1,793.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	121.50	121.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,745.27</b>	<b>689.52</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	2,697.97	689.52
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,697.97	689.52
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	22,047.30	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,047.30	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>60.00</u></b>	<b><u>180.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>60.00</b>	<b>180.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>60.00</b>	<b>180.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	60.00	180.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60.00	180.00

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(60.00)</u></b>	<b><u>(180.00)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	129,813.40	137,594.20
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	129,813.40	137,594.20
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	129,813.40	136,904.68
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,173.00	58,125.95
210101	Үндсэн цалин	54,173.80	50,184.17
210102	Нэмэгдэл	3,999.20	7,941.78
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,558.70	7,558.70
210201	Тэтгэврийн даатгал	5,319.10	5,319.10
210202	Тэтгэмжийн даатгал	559.90	559.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	447.90	447.90
210204	Ажилгүйдлийн даатгал	112.00	112.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,119.80	1,119.80
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60,887.20	68,063.73
210301	Гэрэл, цахилгаан	1,073.10	888.03
210302	Түлш, халаалт	59,689.50	67,175.70
210303	Цэвэр, бохир ус	124.60	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	623.90	623.90
210401	Бичиг хэрэг	63.00	63.00
210402	Тээвэр, шатахуун	205.50	205.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235.40	235.40
210404	Ном, хэвлэл	60.00	60.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60.00	60.00
2105	<b>Нормативт зардал</b>	95.60	95.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95.60	95.60
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	150.00	150.00

210604	Урсгал засвар	150.00	150.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	281.70	252.00
210702	Дотоод албан томилолт	281.70	252.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,043.30	2,034.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,913.30	1,913.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	130.00	121.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	689.52
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	689.52
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	689.52
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	128,934.80	137,594.20
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	128,934.80	137,594.20
132001	Орон нутгийн төсвөөс	128,934.80	137,594.20
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	0.008	0.008
620001	Удирдах ажилтан	0.001	0.001
620002	Гүйцэтгэх ажилтан	0.003	0.003
620003	Үйлчлэх ажилтан	0.004	0.004

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сантмаргаз сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Сантмаргаз сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2021 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийн №08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сантмаргаз сумын соёлын төв нь соёлын талаар төрөөс явуулж байгаа бодлого шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдэд мэдлэг боловсрол олгох, иргэний болон гоо зүйн хүмүүжил төлөвшүүлэх, тэдний оюуны болон соёлын эрэлт хэрэгцээг хангах, амралт чөлөөт цагийг үр ашигтай зохион байгуулахад нь туслах, хүмүүнлэг эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгддөг Соёлын хууль шинэчлэгдэж, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сантмаргаз сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 129,813.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,947.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 1,460.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	5,120.00	5,245.00	125.00
Үндсэн хөрөнгө	644,790.05	632,625.53	(12,164.52)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>649,910.05</b>	<b>637,870.53</b>	<b>(12,039.52)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	649,910.05	637,870.53	(12,039.52)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>649,910.05</b>	<b>637,870.53</b>	<b>(12,039.52)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 125.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,164.52 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,039.52 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 128,934.8 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 878.2 мянган төгрөгөөр нийт зарлагыг 129,813.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 137,594.2 мянган төгрөгийн, санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 136,904.7 мянган төгрөгийг зарцуулж, 689.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Нягтлан бодогч нь худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй, эд хариуцагч болон жолоочтой тооцоо бодож хэвшээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна..

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн орлогын бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг шалгах

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

### 4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 4,364.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 270.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,359.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,733.8 мянган төгрөгийн шинж чанарын хувьд материаллаг бус алдаанд зөвлөмж өгсөн.

#### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 250.0 мянган төгрөгийн, үр дүнгийн тайланд 20.8 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

#### 4.2.2 Төлбөрийн акт

##### 1.1. Илрүүлэлт:

- ✓ Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, НДШ-ийн зардал, албан томилолт зэргийг илүү тооцож олгосон, цалин хөлснөөс ХХОАТ-ыг суутгаагүй зэргээр 1,359.4 мянган төгрөгийн зөрчил гаргасан

##### 1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3 заалтыг үндэслэн илүү олгосон цалингийн нэмэгдэл, албан томилолтыг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

#### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

#### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

#### 1.1. Илрүүлэлт:

- ✓ 2,733.8 мянган төгрөгийн зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	Сантмаргаз сумын Соёлын төв	4	4.36	2	0.3	1	1.36			1	2.7
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>4.36</b>	<b>2</b>	<b>0.3</b>	<b>1</b>	<b>1.36</b>			<b>1</b>	<b>2.7</b>